



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 онд 04 сарын 10 өдөр

Дугаар А/134

Мандалговь

Г Ажлын хэсэг байгуулах тухай 7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.12, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.4, аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 3.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Дуу хуур бидний өв соёл" сумдын соёл урлагийн өдрүүд болон албан байгууллагуудын урлагийн үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: А.Нарантуяа Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
 Гишүүд: М.Болор-Эрдэнэ Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
 Ц.Бумангэрэл Боловсрол, соёл урлагийн газрын дарга
 Д.Доржсүрэн Төв Халхын дуулалт жүжгийн театрын дарга
 А.Ууганбаяр "Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын захирал
 М.Бямбажав Музейн захирал
 Ц.Одончимэг Төв Номын сангийн захирал

Нарийн бичгийн дарга: Х.Цогзолмаа Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн

Хоёр. Урлагийн үзлэгийн удирдамжийг боловсруулан батлуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг /А.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200462